



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

ЗАЙ ХУРААГУУР- ХОР ТҮГЭЭГҮҮР

II НҮҮРТ

ИХ ХУРАЛД НЭР ДЭВШИГЧЭЭС ТОДРУУЛАХ

АРВАН ЗҮЙЛ

IV НҮҮРТ



ХУУЛИЙН ЗАСАГЛАЛ

Ц.Батболд
Хөгжлийн эдийн засагч (PhD),
олон улсын хуульч

БАЯЛАГИЙН САН ЯМАР БАЙХ ЁСТОЙ ВЭ?

VI НҮҮРТ

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.07.25, №3 (107)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.mn

ЗАЙ ХУРААГУУР- ХОР ТҮГЭЭГҮҮР





Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>



ЗАЙ ХУРААГУУР- ХОР ТҮГЭЭГҮҮР

Монголд ахуйн болон бусад төрлийн зайны хаягдал хэрэглээгээ дагаад нэмэгдсээр байна. Гэтэл ашигласан зай ямар хөнөөлтэйг хүн бүр мэддэггүй. Бүх төрлийн зай нь байгаль орчныг бохирдуулж, ундны усыг хордуулж, иргэдийг өвчлүүлж байгааг төр засаг нь хэмжиж, шалгаж ч чадахгүй байсаар. Айл өрх ашигласан зайгаа ахуйн хогтойгоо холин хаясаар.

Монгол улсад хог ялгах соёл тогтоогүй, хог боловсруулах ганц ч үйлдвэр байхгүй. Төр засаг нь түмэн хөтөлбөр, буман төлөвлөгөө гаргадаг ч хэрэгжсэн ажил бараг алга. Бид ер нь хэдий болтол зай хураагуур бол хор түгээгүүр гэдгийг үл ойшоож, зайг ил задгай хаяж өөрсдийгөө, үр удмаа хохироох юм бэ? ►►

▶ ХЭРЭГЛЭЭ

Монгол улс 3.2 сая хүнтэй, жилд 6 сая ахуйн хэрэглээний зай импортлож байна. Энэ бүх зай эцэстээ айл өрхийн ашигласан хогтой цуг хаягдаж байна.

2018 оны байдлаар улсын хэмжээнд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан 585 мянган тээврийн хэрэгслээс 72 хувь нь суудлын автомашин. Эдгээр суудлын автомашины 83 хувь нь буруу, баруун талдаа хүрдтэй, япон автомашин ба, дийлэнх нь цахилгаан-бензинийн хос хөдөлгүүртэй хуучин Приус. Японд хэрэглэгч 13 жилийн настай хуучин машинаа хаягдалд тушаахад 2500 доллар хүлээн авдаг атал Монголд тэр хаясан машиныг нь 5000 доллараар худалдан авдаг. Приусын зайг нь сольдог ч, хуучин зайг нь яахаа мэдэхгүй хогийн цэгт хаядаг аж.

ХОР ХӨНӨӨЛ

Зайнд хүний сэтгэхүйн болон дотор эрхтнийг хямруулж, үр удмын санд нөлөөлдөг, хорт хавдар үүсгэдэг хүнд металлууд байдаг. Тийм учраас хар тугалга, никель, кадми, мөнгөн ус агуулсан зай, тэдгээрээс ялгасан хүчил, электролитийн уусмал зэргийг төр засаг “аюултай хог хаягдлын жагсаалтад” бүртгэжээ. Бүртгэсэн гэдэг нь хор түгээхийг зогсоосон гэсэн үг огт биш. Монголчууд хуруу зайг шүдээрээ хазаж “сэргээдэг” бол, хүүхдүүд нь гоё зайгаар тоглож, зарим нь задлаж, нялх нь залгиж байна.

Саяхан манай төрийн түшээд, мэргэжлийн байгууллагууд иргэдийн гомдлын дагуу шалгалт хийв. Тэд Налайх дүүргийн Хонхор өртөөнөөс баруун урд автомашины зай (аккумулятор) задлан, хар тугалгыг нь хайлуулаад Хятад руу

гаргадаг Монгол, Солонгос, Хятадын хөрөнгө оруулалттай гурван өөр компани дээр очжээ. Компаниуд өдөрт нэгээс хоёр тонн машины зайг 1 кг-ыг нь 1600 төгрөгөөр иргэдээс аваад сүхээр хагалж, хар тугалгыг нь хайлуулан гулдмай болгож, хүхрийн хүчлийг нь газарт суулгасан бетон саванд юүлсэн гэдэг ч бүгд хөрсөнд нэвт шингэн, Туул голын сав газрыг хэдэн жил хордуулж иржээ. Энэ бол зөвхөн мэдэгдсэн нь, мэдэгдээгүй олон арван ийм компаниуд байгаа.

Автомашины зай ашиглалтын хугацаа нь дууссанаас хойш их хэмжээний хорт бодис орчиндоо ялгаруулдаг. Ширхэг хуруу зай дөрвөн ам метр хөрс, 8000 литр ус бохирдуулдаг. Хэрэглэсэн хуруу зай 100-аад жилийн дараа л хөрсөнд шингэж алга болдог.

ШИЙДЭЛ

Бүх төрлийн зайн хэрэглээ улам бүр өсч буйг дурдсан. Харин зайн хаягдлыг манайд газарт булдаг, эсвэл шатааж байна. Нэг компани нэлээн хэдэн тонн зай цуглуулаад Япон руу явуулахыг оролдсон ч, хоёр хөрш нутаг дээгүүрээ хортой бодис нэвтрүүлдэггүй ажээ. Ашиглаж дууссаны дараа зайг цуглуулан, ялгаж, дахин ашиглахаас өөр сонголт бидэнд үлдсэнгүй.

Монгол Хог хаягдлын тухай хуультай ч хог боловсруулах үйлдвэр барих хөрөнгө байхгүй, газраа ч сонгож чадахгүй сууна. Энд тэнд хуруу зай хүлээж авах ганц нэг цэг байгуулсан ч, цааш нь яахаа мэдэхгүй байна.

Иймд зайн хураагуур импортлох, худалдан борлуулахад багахан татвар аваад орлогыг нь тодорхой шаардлага хангасан компанид шилжүүлж, цуглуулах, боловсруулах үйлдвэр байгуулж, эргэлтэнд оруулахыг даалгах нь хамгийн өгөөжтэй шийдэл юм.

2019.07.24

ИХ ХУРАЛД НЭР ДЭВШИГЧЭЭС ТОДРУУЛАХ АРВАН ЗҮЙЛ

Та Монгол Улсын Их Хурлын сонгуульд өрсөлдөж байна. Энэ шийдвэрээ олныг эргэцүүлж, нэгийг бодож гаргасан гэдэгт итгэлтэй байна. Хэрэв Та "defacto" ярилцлагаар орсон бол Танаас дараах арван зүйлийг тодруулмаар байна. Үүнд:

1 Таны Их Хурлын гишүүн болох туйлын зорилго юу вэ? Хамгийн чухал гурван зорилтоо хэлнэ үү? Энэ бүхэн чин үнэн гэдгийг эх, эцгийнхээ нэрийг барьж тангараглаж чадах уу? Таны сонгуулийн сурталчилгааны уриа юу вэ? Та түүндээ бүрэн итгэж байна уу? Урианы хэрэгжилтээ хэмжиж чадах уу? Хэмжиж чадахгүй юмыг удирдах боломжгүй гэдэг шүү дээ.

2 Монголын үндэсний аюулгүй байдалд хамгийн ноцтой заналхийлж байгаа засаглалын авлигыг хаанаас нь эхлэж цэвэрлэх вэ? Улаанбаатар хотын газар болон ашигт малтмалын лицензийн наймааг удирдаж байгаа төр-бизнесийн зохион байгуулалттай гэмт хэргийг яаж зогсоох вэ? "Зайсандах" буюу хуулийг өөрсдөдөө тохируулан засдаг монгол жишгийг яаж өөрчлөх вэ? Хуулийн хэрэгжилтийн дээд шалгуур байх ёстой Үндсэн хуулийн Цэц өөрөө Зайсанд ордон барьж авлигыг Богд уулнаасаа илүүтэй дархлан хамгаалсныг яаж вэ?

3 Та муур хулганы үлгэр шиг болсон гол мөрөн, ойн сав газарт ашигт малтмалын хайгуул, олборлолт явуулахыг хориглосон "урт нэртэй хуулийг" хэрэгжүүлж чадах уу? Монгол улс уул уурхайн орлогоороо юу хийвэл эдийн засгаа төрөлжүүлнэ гэж боддог вэ?

4 Та манлайлагч мөн үү? Шийдвэр гаргахад нь бусдад нөлөөлж чадах уу? Нийтийн засаглалд шударга ёс тогтоохын төлөө юу хийх вэ?

Өнгөрсөн сонгуулийн үймээнээр нэг намын байр, соёл урлагийн ордон шатсан ч төрийн эрх баригчид төсвийн 14 тэрбум төгрөгөөр сүрлэг том ордон барьсан атлаа соёл урлагийн ордныг шатсан балгас хэвээр нь үлдээсэнд та ямар дүгнэлт хийж байна вэ? Таван хүнийг хэн буудаж алсныг мэдэн будилж, улс төрийн жүжиг тавьсаар дараагийн сонгууль хүргэж байгааг юу гэж үзэж байна вэ?

5 Эх орноо хөгжүүлэн бадраах их үйлсийг удирдан жолоодоход Та өөрийнхөө мэдлэг, боловсрол, ёс зүй, соёл, гадаад хэлний чадвараа хангалттай гэж дүгнэж байна уу? Даяаршсан монголыг дан хэлээр удирдах боломжгүй шүү.

6 Өөрийгөө удирдаж чаддаггүй хүн бусдыг удирдаж чадахгүй гэдгийг Та хүлээн зөвшөөрдөг үү? Төрөөс тэрбумтан төрсөөр байгааг яаж зогсоох вэ? Танай намд хандив өгөх нэрээр мөнгөтэй нэг нь өндөр албан тушаал худалдан авч байгааг зогсоож чадах уу? Хэрэв та өмнө нь Их Хурлын гишүүн байсан, ялангуяа намын нэрсийн жагсаалтанд энэ удаа орсон бол авлигыг хазаарлахын тулд яг юу хийсэн бэ? Эсвэл Та "тогтолцооны буруу" гэж өөрөөсөө зайлуулан, юу ч хийгээгүй юу? Та дуугүй явснаараа шударга бусыг өөгшүүлэн дэмжиж ирсэн үү? Эсвэл та том томоор намдаа хандив өргөн "лангуу биш дэлгүүрийг" нь бүхэлд нь худалдаад авчихдаг "үнэмлэхүй авлигачдын" нэг үү?

- 7** Та Их Хурлын гишүүн болоод юуны өмнө хувийнхаа хэрэгцээг хангах төлөвлөгөөтэй байна уу? Төр засгийн өндөр албан тушаалаа ашиглан өөрт холбоотой компаниудаа өргөжүүлж, монополь ашиг олгох нөхцлийг олгодог 21-р зууны монголын засаглалын луйварчин уламжлалыг үргэлжлүүлэх үү? Хэрэв та тийм нууц санаа өвөрлөж яваа бол төр нь баялаг бүтээдэг биш, түүнийг хуваарилдаг газар бөгөөд ардчилал, шударга ёс хөгжихийн хэрээр нийтийн дэл сул хөрөнгө улам бага болж, түүнд халдсан хэнтэй ч гэсэн хариуцлага тооцно гэдгийг анхаарна уу. Энэ бол цаг хугацааны л асуудал.
- 8** Та Их Хурлын гишүүний хувьд Монгол улсын, иргэд бидний нүүр царай болно. Таны үг яриа, үйл ажиллагаа олон хүнд, ялангуяа залуучуудад зөв сайхан үлгэр дуурайл болно гэдэгт итгэж байна уу?
- 9** Таны сонгуулийн сурталчилгааны зардал хаанаас гарсан бэ? Хэнээс хэчнээн хандив авснаа сонгуулийн нярав тань тодорхой бүртгэх ёстой. Та зардлын тайлангаа ялсан ч, үгүй ч гаргах ёстой. Та баахан өр тавьж төрийн эрхийг авмагцаа зээлдэгчийнхээ эрх ашгийг хамгаалсан хууль журам гаргах, тендерт ялуулах, албан тушаал бэлэглэх зэрэг замаар төлөх гэж байгаа бол үүнийг засаглалын авлига гэдэг. Хуулиар таныг шийтгэх болно.
- 10** Их Хурлын гишүүн Та ард түмнийхээ дарга нь биш зарц нь болж буйгаа хүлээн зөвшөөрөх үү? Нийтийн (төрийн) ажилтнууд тухайн нийгмийн ёс зүйн өнгийг илэрхийлдэг. Та төрийн ажлыг мэргэжил гэж ойлгоод үр хүүхдэдээ уламжлуулан, эзэмшүүлэхийг хичээж байгаа юу гэж үздэг вэ?

Нэр дэвшигч Та дээрх асуултуудын ихэнхэд итгэл төгс хариулж байгаа бол баяр хүргэе. Ихэнхийг нь хариулж чадахгүй, эргэлзэж байгаа бол өөрийн болон бусдын олон зуун сая төгрөгийг салхинд хийсгэх ёс зүй, шаардлага байна уу? Харин түүний оронд энэ их хөрөнгөөр Монгол шиг буурай оронд хэд хэдэн цэцэрлэг, сургууль байгуулж, зам харгуйгаа засч болохыг битгий мартаарай.

Эрхэм сонгогч Та ч гэсэн дээрх асуултуудад хариу авсныхаа дараа л Их Хуралд өөрийн төлөөлөгчөө сонгохыг уриалж байна. Эцсийн эцэст ямар ард түмэн байна, тийм төр засаг л байдаг. Ард түмэн хичээвэл арай цэвэрхэн төр гарах болно.

Сонгогч та бүхэнд зориулж 2012.06.07-нд бичиж байсан нийтлэлээ дахин хэвлэж байна.



Ц.БАТБОЛД

Хөгжлийн эдийн засагч (PhD), олон улсын хуульч бөгөөд АНУ-д мэргэжлээрээ ажиллаж байна.


НИЙТЛЭЛ

БАЯЛАГИЙН САН ЯМАР БАЙХ ЁСТОЙ ВЭ?

“Зах зээлийн эдийн засагт хүмүүс хэрэглээгээ харьцангуй баталгаатай орлогын түвшинд байлгаж, түр зуурын орлогыг хэрэглэхгүй хадгалах замаар хөрөнгийнхөө түвшинг буюу амьжиргааныхаа суурийг бууруулахгүй байхыг эрмэлзэж байдаг” тухай Нобелийн шагналт М.Фридманы “Permanent income hypothesis” (PIH) буюу “Байнгын орлогын төсөөлөл” гэдэг онол байдаг. Энэ нь “хүн ажил хийж олох орлогоо амьдралынхаа туршид жигд хуваарилахын тулд хүүхэд залуудаа, бусдаар тэтгүүлж ажиллаж байхдаа хадгалж хурааснаасаа хөгшрөхдөө хэрэглэдэг тухай” Нобелийн шагналт Ф.Модиглианийн “Амьдралын мөчлөг” онолтой бас тохирдог, эдийн засгийн тоо баримтаар сайн нотлогдсон зүй тогтол юм. Макро

эдийн засгийн эдгээр үндсэн зарчим нь хувь хүн, бизнес байгууллага төдийгүй ирээдүйгээ боддог улс орны ч төрийн бодлогод баримтлах ёстой удирдамж юм. Ялангуяа түр хэрэглээд дуусчих байгалийн баялагтай орнуудын хувьд баялагаас олох орлогыг жигд зохистой хуваарилан хэрэглэж, баялаг дууссан хойно ч орлого үргэлжлэх хуримтлал бий болгох нь төсвийн бодлогын гол зорилт байдаг. Үүний тулд “Natural resources fund” буюу Байгалийн баялагийн сан байгуулдаг ба Чилийн Тогтворжуулалтын сан, Норвегийн Тэтгэмжийн сан, Кувейтийн Ирээдүйн сан, Оросын Нефтийн сан, Ботсваны Пула сан зэрэг нь түүний жишээ юм.

1. Энэ нь үндсэндээ байгалийн баялагаас хүртэх орлогоо жил бүр тогтмол хүү “annuity” төлж байдаг хугацаагүй бонд буюу “perpetuity” болгоно гэсэнтэй төстэй юм. Ийм нөхцөлд баялагийн орлого эхлэхээс өмнө сангийн жилийн хүүтэй тэнцэх зардлыг баялаг дууссан хойно ч төсвөөс байнга гаргах боломж бүрддэг. Жишээ нь таван жил хөрөнгө оруулж, тавин жил ажиллах уурхайгаас олох орлого, түүнээс хуримтлуулах баялагийн сан ба төсвөөр дамжуулан гаргаж болох зардлыг дүрслэж үзүүлье.



Ийм сангийн сонгодог жишээ нь Норвегийн сан бөгөөд тэд урьдчилан зээл авч өр тавилгүй, орлого эхлэхийг хүлээсний ачаар баялагийн сан ба түүнээс төсөвт жил бүр төлөх хүүгийн хэмжээ нь PIH зарчмаас ч өндөр тогтсон байна. Түүгээр ч барахгүй төсвийн алдагдлаа сангийнхаа хүүгийн дөрвөн хувь түвшнээс доогуур, ихэнхдээ ашигтай барьж чадсанаар сангийн ба хүүгийн дүн хэмжээ өссөөр байна. Баялагийн санг ингэж жинхэнэ утгаар нь ажиллуулахад улс төрчдийн мэдлэг хариуцлага, сонгогч ард түмний ухамсар дэмжлэг шийдвэрлэх үүрэгтэй байдаг бөгөөд орон бүр чаддаггүй. Жишээ нь Орос бас ийм нефтийн сан байгуулсан боловч улсын төсвийн алдагдал нь сангийнхаа хүүгээс хэтэрч ирсний улмаас 2016 онд ҮНБ-ий долоон хувьд хүргэхээр төлөвлөж байсан сан, ялангуяа 2014 оноос нефтийн үнэ буурснаар одоо ҮНБ-ий нэгээс хоёр хувь хүртэл багасжээ. Санг нөхөх зорилтоо 2021 хүртэл хойшлуулсан боловч төсвийн бодлого эрс өөрчлөгдөөгүй нөхцөлд биелэх найдваргүй.

2. Хөгжлийн хэрэгцээ ихтэй буурай орнуудын хувьд баялагийн орлогынхоо ихэнхийг дэд бүтэцээрэгудаан хугацаандашиглагдах капитал болгох нь PИH шиг санхүүгийн хуримтлалаас ашигтай гэж хөгжлийн эдийн засагчид (Оксфордын П.Коллиер зэрэг) үздэг. Гэхдээ эдийн засаг дахь гацаа түгжээг тайлж, өсөлтийг бодитой хурдасгаж чадах, хувийн хэвшлийг шахах биш татах (crowd in, not out), төсвийн зардал хэтэрч, хэт тэлэлт үүсгэхгүй хөрөнгө оруулалт байх шаардлагатай учир эхлээд эдийн засгийн “absorptive capacity” буюу шингээх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн “investing in investment” буюу хөрөнгө оруулалтын мэдлэг чадвараа сайжруулж, системтэй яаралгүй хийхийг зөвлөдөг. Ийм сангийн нэг жишээ нь Ботсваны Пула сан. 1966 онд тусгаар тогтнохдоо Африкийн хамгийн ядуу орны нэг байсан бол экспортын 90% төсвийн орлогын 40%-ийг бүрдүүлдэг алмаз голлосон уурхайн гадаад хөрөнгө оруулалт татаж, баялагийн орлогоо тусгай санд төвлөрүүлэн, зөвхөн хөрөнгө оруулалт, онцгой тохиолдолд валютын ханш тогтворжуулахад ашиглах замаар 1989 он гэхэд дундаж өндөр орлоготой орон болжээ. Мөн төсвийн баланс эдийн засгийн мөчлөгийн дунджаар заавал ашигтай байх, үүний тулд төсвийн зардлыг 2016 он гэхэд ҮНБ-ий 40%-аас 30% болгон бууруулах, өрийн түвшинг ҮНБ-ий 20%-аас хэтрүүлэхгүй байх заалттай төсвийн хууль 2005 онд баталж, хэрэгжүүлжээ.

Норвеги, Ботсваны баялагийн сан Төв банкинд байршиж, хөрөнгө оруулалтын урт хугацааны төлөвлөгөө, Сангийн яамны дунд хугацааны төсвийн хүрээ, жилийн төсвийн зохицуулалтын дагуу мэргэжлийн удирдлагатай ажилладаг бол Чилид эрдэмтэд мэргэжилтнээс бүрдсэн зөвлөх комисс сангийн ажлын гол үзүүлэлтүүдийг тогтоодог байна.

3. Зарим орнууд байгалийн баялагтай заавал холбоогүй, улсын хөрөнгө оруулалтаар хувийн сектор чадахгүй байгаа шинэ салбар, эдийн засгийн төрөлжилт (diversification) хөгжүүлэх зорилготой “Sovereign wealth fund” буюу төрийн өмчлөлийн сан байгуулдаг. Ерөнхий энэ нэр дор олон янзын хэлбэр байдаг боловч нийтлэг шинж нь хамгийн эрсдэл ихтэй “Venture capital” маягийн хөрөнгө оруулалт хийх тул маш өндөр мэдлэг туршлага, ашгийн тооцоо шаарддаг. Жишээ нь Сингапурын Темасек сан бусад компанид хувьцаа эзэмшигч “Holding company” хэлбэртэй, доод бүх компани алдагдалгүй ажиллуулах үүрэгтэй байдаг. Тийм ч учраас Сингапурын төрийн алба, компанийн удирдах ажилтнуудыг тухайн салбарын шилдэг менежерүүдээс хувийн секторт авах, орлогоор

нь цалинжуулахаар сонгодог. (Сингапурын Ерөнхий сайд шиг өндөр цалинтай удирдагч дэлхийд байхгүй гэдэг). Абу Дабигийн хөрөнгө оруулалтын сан ихэнх нь “private equity” буюу хувийн өмчлөлийн эрсдлээр мэргэшсэн гадаадынхан ажиллаж, хариуцсан хөрөнгө оруулалтынхаа үр дүнгээр цалинждаг байдал ажиглагдсан.

Монголын хувьд энэ санг байгуулах улс төр, эдийн засгийн нөхцөл бүрдээгүй төдийгүй, төсвийн хөрөнгийг албан ёсоор үрэх бас нэг том үүд нээгдэх аюултай санагдана. Учир нь төрийн өмчийн захирагч ийм сан гаргасан хохирлоо “бизнес гардаг л алдагдал” гэх тул авсан зээлээ төлөхгүй бол хөрөнгийг нь хураах эрхтэй Хөгжлийн банкнаас ч дор байдал үүснэ. Үүний оронд хөрөнгөө гаргаж, эрсдлээ хариуцах олон улсын санхүүгийн байгууллага, гадаад дотоодын хөрөнгө оруулагчтай “private equity” маягийн хувийн сангууд ажиллах эрх зүй, бизнесийн орчинг бүрдүүлэх нь илүү ирээдүйтэй юм.

4. Зэсийн урт хугацааны дундаж үнээр тооцсон суурь орлогын хэмжээнд төсвийн зардлаа барьж, гадаад өрийг ҮНБ-ий 40%-аас хэтрүүлэхгүй байх тухай монголд 2012 онд мэргэжилтнүүд боловсруулж өгсөн төсвийн хариуцлагын хуулийг хэрэгжүүлсэн бол өнөөгийн их өр алдагдлаас сэргийлж чадах байсан. Гэхдээ баялагийн сан бүрдүүлэхийн тулд бид наад зах нь төсвийн баланс алдагдалгүйгээр барахгүй, хуримтлал үүсэхүйц ашигтай болох шаардлагатай. Хамгийн гол нь ОТ-г дахин гацаахгүй, ТТ-г дахин хойшлуулахгүй ашиглах замаар баялагийн санд хураах орлогоо эхлээд бүрдүүлэх хэрэгтэй. Тэгэхгүйгээр олон жил үргэлжлэх өрийн хүнд дарамт дор өндийж ядаж байгаа эдийн засаг дефолт байтугай дампууралд хүрнэ. Баялагийн сан нэрээр нэмж зээл аван төрийн өмчид тулгуурласан шинэ үйлдвэрлэл хөгжүүлнэ гэдэг орчин үед огт бүтэхгүй бөгөөд, төвлөрсөн төлөвлөлтийнх шиг алдагдалтай олон үйлдвэр, Зөвлөлтийнх шиг их өр, магадгүй өөр хөршийн мэдэлд дахин амилах аюултай. Сүүлийн жилүүдэд ОУВС байгалийн баялагтай орнуудын өр, хөрөнгө оруулалт, өсөлт, баялагийн орлогын зөв зохистой удирдлагад туслах зорилготой DIGNAR (Debt, Investment, Growth, Natural Resources) гэдэг төлөвлөлтийн модель боловсруулж, хэдэн жилийн өмнө монголд тохируулсан тооцоо хийсэн. Энэ моделийг шинэчлэн нутагшуулж, холбогдох ажилтнууд, улс төрчдөд танилцуулж сургавал баялагийн сантай болох замд нэн цагаа олсон бэлтгэл болмоор санагдана.

2018 оны 5-р сар

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

ДАВАА ГАРАГ БҮР



НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916

WWW.MONGOLPOST.MN

Та "Дефакто Газет" цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

✉ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com